



## ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 23 өдөр

Дугаар А/396

Хэрлэн сум


### Газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 49 дүгээр тогтоолоор батлагдсан Дуудлагын худалдааны талаар авах арга хэмжээний 2 дугаар зүйлийн 2.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Нийтлэг үйлчилгээ" Орон нутгийн өмчийн газрын Баян-Эрдэсийн байрны 1 дүгээр давхар (газрын хамт)-ын 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулагдсан Эд хөрөнгийн нээлттэй дуудлага худалдаанд оролцсон хамгийн өндөр үнэ өгч, худалдах худалдан авах гэрээний дагуу эд хөрөнгийн үнийг бүрэн төлсөн тул иргэн Баатархуяг овогтой Ононхэрлэнд (РД:СД81122402) Хэрлэн сумын 4-р баг Тэмүүжин гудамж А-49-02 тоотод байршилтай Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолборын зориулалттай 1971 м<sup>2</sup> газрыг 60 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, гэрээний биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Б.Сүнгээ)-д, Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг иргэн Б.Ононхэрлэнд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ